



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/400

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Галсангийн Нарангэрэлийн эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг Хуучнаар хангамжийн хойд талд байрлах, Үйлдвэрлэлийн зориулалттай 5518 м² газрыг иргэн Галсанжамцын Цэндсүрэнд 47 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэн Галсанжамцын Цэндсүрэнгийн эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Г.Цэндсүрэнд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аумгийн Засаг даргын 2005 оны 35 дугаар захирамжийн хавсралтын 1 дүгээр хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА